


Үнэлгээг сайжруулахад шалгуурыг сайжруулах нь

Үнэлгээний шинэчилсэн шалгуур
Тэдгээрийн тодорхойлолт ба ашиглах зарчим

ЭЗХАХБ/ХТХ-ны Хөгжлийн үнэлгээний сүлжээ



Better Criteria for Better Evaluation
Revised Evaluation Criteria Definitions and Principles for Use - Mongolian language translation

OECD/DAC Network on Development Evaluation © 2023

Introduction to the Mongolian version

The Mongolian language translation of “OECD DAC Better Criteria for Better Evaluation” has been made possible by members of the Mongolian Evaluation Association (MEA), EvalYouth Mongolia Chapter and the Organisation for Economic Co-operation and Development (OECD) Development Co-operation Directorate. The process of producing this work has itself contributed to building national evaluation capacity as the translation, reviewing and editing was all done by the members on a voluntary basis. This translation uses key terms consistent with the ‘OECD DAC Glossary of Key Terms in Evaluation and Results Based Management for Sustainable Development’ translated by MERIT Mongolia.

We extend our special thanks to all our translators, namely, Khas-Erdene Chuluunbat, Delgermurun Sukhbaatar, Byambasuren Uuganjargal, Oyuntsetseg Khurts, Lkhagvadulam Chimeddamba, Dr. Ganzorig Gonchigsumlaa, Oyundalai Odkhoo and Myagmartsermaa Delgersaikhan, and to our editors Uelunzaya Delgerjav, Bayarmaa Lkhagvadorj, Lkhagvadulam Chimeddamba and Davaadulam Tsegmed who graciously provided numerous iterations of rigorous reviewing and editing of the translation.


This new Mongolian language version will be a living document to be revised and improved over time reflecting more nuanced and contextualized translation suggested from users.

This document will benefit all stakeholders of evaluation in government, civil society organizations, evaluation commissioners, evaluators and users of evaluation, providing shared understanding about the criteria. In addition, it will contribute to building national evaluation capacity to apply criteria thoughtfully and properly, and to increase the value of evaluation in the society.


Megan Kennedy-Chouane,
Head of Evaluation Unit
Development Cooperation Directorate
Organisation for Economic Co-operation and
Development (OECD)



Erdenechimeg Ulziisuren,
Founder and President
Mongolian Evaluation Association (MEA)



Byambasuren Uuganjargal,
Co-Founder, EvalYouth Mongolia Chapter
Member, Mongolian Evaluation Association



Монгол орчуулгын танилцуулга

“Үнэлгээг сайжруулахад шалгуурыг сайжруулах нь” хэмээх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын Хөгжлийн тусламжийн хороо (ХТХ)-ноос гаргасан энэхүү товхимолыг Монголын үнэлгээний холбоо, EvalYouth Mongolia салбарын гишүүд болон ЭЗХАХБ-ын дэмжлэгтэйгээр англиас монгол хэл рүү орчуулан та бүхний гарт хүргэж байна. Гишүүд өөрсдийн сайн дурын үндсэн дээр орчуулах, засварлах, хянах бүхий л ажлыг хийсэн нь үнэлгээний чадавхийг бэхжүүлэх үйл явц байлаа. Энэхүү товхимол нь MERIT төслийн орчуулан гаргасан “ЭЗХАХБ-ын ХТХ-ны Тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томъёоны тайлбар толь”-ийн нэр томъёоны орчуулгыг суурь болгосон.

Товхимолыг орчуулсан Чулуунбатын Хас-Эрдэнэ, Сүхбаатарын Дэлгэрмөрөн, Ууганжаргалын Бямбасүрэн, Хурцын Оюунцэцэг, Чимэддамбын Лхагвадулам, Др. Гончигсумлаагийн Ганзориг, Одхүүгийн Оюундалай, Дэлгэрсайханы Мягмарцэрмаа, мөн засварлаж, хянан тохиолдуулсан Дэлгэржавын Өэлүн, Лхагвадоржийн Баярмаа, Чимэддамбын Лхагвадулам, Цэгмэдийн Даваадулам нартаа чин сэтгэлээсээ талархаж байна.

Энэхүү товхимол нь хэрэглэгчдээс ирсэн санал, шүүмжийг тусган үе үе шинэчлэгдэж, улам сайжирч явах амьд товхимол байх болно.

Шалгууруудыг утга учиртай, зөв хэрэглэх үндэсний үнэлгээний чадавхийг бүрдүүлэх, нийгэмд үнэлгээний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд бидний орчуулсан энэ товхимол чухал хувь нэмрээ оруулж, төр, иргэний нийгмийн байгууллагууд, үнэлгээг захиалагчид, үнэлгээчид, үнэлгээний хэрэглэгчид гээд үнэлгээний бүхий л оролцогч талуудад тус дэмээ өгнө гэж найдаж байна.

Меган Кенеди-Шуане,
Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн
байгууллага (ЭЗХАХБ)-ын Хөгжлийн хамтын
ажиллагааны газрын Үнэлгээний нэгжийн
дарга

Megan J. Kennedy-Chouane

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг,
Монголын үнэлгээний холбооны Үүсгэн
байгуулагч, ТУЗ-ын дарга

О. Эрдэнэчимэг

Ууганжаргалын Бямбасүрэн,
EvalYouth Монгол салбарын Хамтран үүсгэн
байгуулагч, Монголын үнэлгээний холбооны
гишүүн

Бямбасүрэн

1. Оршил

1.1. Шинэчлэн боловсруулах үндэслэл

1. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (цаашид “ЭЗХАХБ” гэх)-ын Хөгжлийн тусламжийн хороо (цаашид “ХТХ” гэх) үнэлгээний шалгуурыг (нийцтэй байдал, үр нөлөөдүнтэй байдал, үр ашигтай байдал, нөлөөлөл, тогтвортой байдал) анх 1991 онд ЭЗХАХБ-ын ХТХ-ны “Хөгжлийн тусламжийн үнэлгээний зарчмууд”-д тусгаж, хожим 2002 онд гаргасан “Үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томъёоны тайлбар толь”-д нэр томъёог тодорхойлсон юм. Эдгээр таван шалгуур нь олон улсын хөгжлийн болон хүмүүнлэгийн төсөл, хөтөлбөр, бодлогуудыг үнэлэхэд гол эх сурвалжаар ашиглагдаж байна. Үнэлгээний мэргэжилтнүүд болон захиалагчид эдгээр шалгуурыг хөгжлийн хамтын ажиллагаанаас гадна төрийн бодлогын бусад салбарт мөн ашиглах болсон.

2. 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон Тогтвортой хөгжлийн зорилгууд (цаашид “2030 Хөтөлбөр” гэх), мөн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн үндэстний байгууллагын суурь конвенцийн хүрээнд Парисын хэлэлцээр (цаашид “Парисын хэлэлцээр” гэх)-ийг 2015 онд баталсны дараа олон улсын үнэлгээний мэргэжилтнүүд шалгуур ашиглах болсон 25 жилийн туршлагадаа үндэслэн тэдгээрийг шинэчлэн боловсруулах талаар хэлэлцэж эхэлсэн юм. ЭЗХАХБ-ын ХТХ 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Дээд түвшний хурлаараа “төсөл, хөтөлбөрийн үнэлгээний таван шалгуурыг 2030 Хөтөлбөртэй нийцүүлж, шинэчлэн боловсруулах” шийдвэр гаргасан. Уг шийдвэрийн дагуу бодлого боловсруулах, мэдлэг олгоход ашиглах нотолгоо, мэдээллийн суурь бүрдүүлэх, үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ХТХ-ны салбар байгууллага болох Хөгжлийн үнэлгээний сүлжээ (цаашид “EvalNet” гэх) 2018-2019 оны хугацаанд үнэлгээний шалгууруудыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.

3. Шинэчлэн боловсруулах үйл явцын зорилго нь өнгөрсөнд хуримтлуулсан сургамж, туршлагыг цэгнэн үзэж, улмаар үнэлгээний шалгуурыг сайжруулах явдал байв. Сайн шалгууртай байх нь сайн үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлнэ. Сайн үнэлгээ хийснээр 2030 Хөтөлбөр, Парисын хэлэлцээр болон бусад зорилгуудыг хэрэгжүүлж, үндэстний хувь нэмрийг хангах илүү сайн бодлого боловсруулахад дэмжлэг болох юм.

1.2. Шалгуурын талаарх зөвлөлдөөн: давуу тал болон сайжруулах шаардлагатай хэсгүүд

4. Шалгуур шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 2018 оны 5-11 дүгээр сарын хооронд олон нийтийн санал асуулга, ярилцлага зохион байгуулах, олон улсын хурал, уулзалтаар хэлэлцүүлэх, баримт бичгийн судалгаа хийх зэрэг олон төрлийн зөвлөлдөөн хийв. Улмаар эхний байдлаар боловсруулсан төсөлд үндэслэн зөвлөлдөөн 2019 оны сүүл хүртэл үргэлжилсэн. Зөвлөлдөөнөөс гарсан үр дүнгийн хураангуйтай танилцах боломжтой.¹

5. Мэргэжилтнүүд үнэлгээний шалгуурыг өргөн хүрээнд дэмжин ашигладаг болох нь зөвлөлдөөний явцад ажиглагдав. Оролцогчид одоо ашиглаж буй

¹ ХТХ-ны Хөгжлийн үнэлгээний холбоо (2018), ХАЭЗХБ ХТХ Үнэлгээний шалгуурууд: Зөвлөлдөөний үр дүнгийн хураангуй (2018 оны 11-р сар). Эндээс үзэх: oe.cd/criteria

үнэлгээний шалгуур нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, нийтлэг хэрэглээ сайтай хэмээн дүгнэж, шалгуурын үндсэн агуулга, ангиллын бүтцийг хадгалан үлдэхийг илүүд үзсэн. Мөн үнэлгээний салбар болон практикт нэгдсэн жишиг тогтоох, жигд хэрэглээ нэвтрүүлэхэд шалгуур ашиглахын үнэ цэн оршихыг онцолж байв. Шалгуурын тоог нэмэгдүүлэхгүй, мөн тодорхойлолт хоорондын харилцан уялдаатай байдлыг хадгалан үлдэж, энгийн хэвээр байлгах шаардлагатай нь илэрхий байв.

6. Үүний зэрэгцээ зарим ойлголтыг илүү тодруулах хүсэлтүүд ирсэн. Практикт үнэлгээний шалгуур ашиглахад тулгардаг асуудлуудын талаар олон оролцогч онцолсон ба эдгээрийн дунд үнэлгээ хийхдээ хэт олон шалгуур, хэт олон асуулт ашигладаг түгээмэл хандлага байгаа нь хамгийн асуудалтай болохыг тодорхойлов. “Хөгжлийн үнэлгээний чанарын стандарт” гарын авлагад тодорхой заасанчлан үнэлгээ хийхэд бүх шалгуурыг заавал бүрэн хамруулах шаардлагагүй ба үнэлгээний бусад төрлийн шалгуур авч ашиглах боломжтой ч практикт тухайн үнэлгээний агуулга, зорилгыг сайн бодолцолгүйгээр шалгуурыг шууд авч ашиглах нь элбэг байна. Түүнчлэн анхны багц шалгуур нь 2030 Хөтөлбөрийн үзэл баримтлал, өнөөгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хангалттай түвшинд тусгаж чадаагүй гэж үзсэн. Зөвлөлдөөнд оролцогчдын зарим нь одоогийн шалгуур төслийн үнэлгээнд хэт чиглэсэн шинж чанартай гэж үзсэн ба үйл ажиллагааны цогц байдал, харилцан буулт хийх хэрэгцээ болон тэгш боломжийг тодорхойлох, түүнчлэн хүний эрх ба жендэрийн тэгш байдлыг илэрхийлэх асуудлыг хангалттай тусгаж чадаагүй гэж үзэв. Олон оролцогч үнэлгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор шалгуурын хэрэглээг дэмжихийн тулд удирдамж, гарын авлагыг сайжруулах хүсэлт гаргав.

7. Зөвлөлдөөний үр дүнд үнэлгээний шалгуур, тэдгээрийн тодорхойлолтоос гадна үнэлгээний практик болон системд буй хэд хэдэн сул талыг ил болгов. Үнэлгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийнхээ дагуу EvalNet сул тал болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам эрэлхийлж, дэлхийн үнэлгээний нийгэмлэгийн түншүүдтэй хамтран ажиллахаар зорьж байгаа бөгөөд одоогоор нэмэлт судалгаа хийх боломжийг судалж байна.

1.3. Шинэчлэн боловсруулсан шалгуурын гол онцлог

8. ЭЗХАХБ, ХТХ-ны Дээд түвшний хурлаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэж, мөн зөвлөлдөөний явцад олж авсан мэдээлэлдээ үндэслэн сайжруулснаар EvalNet шалгуур ашиглахад зориулсан тодорхойлолт ба тэдгээрийг ашиглах зарчмыг шинэчлэн боловсруулав. EvalNet-ийн гишүүд болон түншүүд баримт бичгийн төсөлд хоёр удаа санал өгч, улмаар тодорхойлолтуудыг нарийвчлан хэлэлцэж, санал солилцох цуврал вебинар зохион байгуулав. Мөн олон улсын үнэлгээний экспертүүдийг урьж, баримт бичгийн төсөлд саналаа тусгахыг хүссэн.

9. Дээрх бүх саналд үндэслэн шинэчлэн боловсруулсан шалгуур нь дараах онцлог шинж чанартай болсон:

- Анхны таван шалгуурын шинэ болон сайжруулсан тодорхойлолт: утга санааны ойлгомжтой байдлыг хадгалж, тодорхойлолтуудыг боловсронгуй болгосон ба ойлголтыг тайлбарлахдаа тэмдэглэл ашиглахын зэрэгцээ текстийг аль болох богино, энгийн байдлаар бичсэн.
- Холбоо хамаарал, системийн сэтгэлгээ, түншлэлийн динамик болон үйл ажиллагааны нарийн төвөгтэй, цогц байдлыг үр дүнтэй тусгах зорилгоор “уялдаа холбоо” гэх нэгэн чухал шалгуурыг шинээр нэмсэн.

- Шалгуурын хэрэглээг дэмжиж, төөрөгдлийг багасгах зорилгоор дараах хэсгийг нэмсэн: тухайн шалгуурын зорилгыг тайлбарласан танилцуулга; ашиглах зарчим; шалгуур тус бүрийн цар хүрээг дэлгэрэнгүй тайлбарласан заавар, мөн өөр өөр үнэлгээнд хэрхэн ашиглах талаарх дагалдах гарын авлага (удахгүй гарах).
- Шалгуурыг төслөөс гадна төрөл бүрийн арга хэмжээний үнэлгээнд ашиглах боломжтой: Үнэлгээнд хамрагдах хөгжлийн болон хүмүүнлэгийн салбарын үйл ажиллагаа, арга хэрэгсэл нь өргөн цар хүрээ хамардгийг харгалзан үзэж “арга хэмжээ” гэх нэр томъёог ашиглав (урьдынх шиг гадны санхүүжилт, хөтөлбөр эсвэл төсөл гэж ашиглахын оронд). Түүнчлэн "хандивлагч" гэх нэршлийг хассан.
- Тэгш боломж, жендэрийн тэгш эрх, “хөгжлөөс хэн ч үлдэж, орхигдох ёсгүй” гэх өнөөгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг илүү сайн хэрэгжүүлэх боломж бүрдсэн: Тодорхойлолтууд, тэр дундаа нийцтэй байдал, үр дүнтэй байдлын тодорхойлолт нь тэгш боломжийн асуудалд илүү нарийвчилсан дүн шинжилгээ хийх боломжийг бий болгоно. Шалгуур нь 2030 Хөтөлбөр болон Парисын хэлэлцээрт тусгасан Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэх хүчин чармайлтуудын (үндэсний, бүсийн эсвэл олон улсын) үнэлгээг хийхэд ашиглагдах боломжтой. Мөн бодлогын тэргүүлэх чиглэл, зорилго өөрчлөгдсөн ч үнэлгээний шалгуурууд нь ач холбогдолтой хэвээр, өргөн хүрээнд ашиглаж болохуйц ерөнхий байдлаар тодорхойлогдсон.
- Тогтвортой хөгжлийн нэгдмэл шинж чанарыг харгалзан үзэж, шалгуурын тодорхойлолт болон хэрэглэх заавар нь шалгуурыг хамтад нь эсвэл хэсэгчлэн ашиглахаас үүсэх давуу болон сул талуудыг тооцсон харилцан уялдаатай байна.



2. Шинэчлэн боловсруулсан үнэлгээний шалгуур

2.1. Үнэлгээний шалгуурын зорилго

10. Үнэлгээний шалгуурын зорилго нь үнэлгээний зорилготой нягт холбоотой. Тодруулбал арга хэмжээний үнэ цэн эсвэл ач холбогдол, ололт амжилтыг тодорхойлоход чиглэгддэг.² Энэхүү баримт бичигт “арга хэмжээ” гэсэн нэр томъёог үнэлгээний судлагдахуун гэдэг утгаар ашигласан болно (Шигтгээ 1-ийг харна уу). Шалгуур тус бүр арга хэмжээг өөр өөр өнцгөөс авч үзэх боломж олгох бөгөөд эдгээр нь арга хэмжээний хэрэгжилтийн үйл явц болон үр дүнгийн талаар цогц ойлголтыг өгөх юм.

11. Шалгуур нь норматив үүргийг гүйцэтгэдэг ба шалгуурууд хамтдаа арга хэмжээнээс хүлээгдэж буй шинж чанарыг тодорхойлдог: бүх арга хэмжээ нөхцөл байдалдаа нийцсэн, бусад арга хэмжээтэйгээ үялдаа холбоотой, зорилгодоо хүрэхүйц, үр ашигтай байдлаар үр дүнд хүрч, үргэлжлэн үлдэх эерэг нөлөөллийг авчрахыг зорих нь зүйтэй.

12. Үнэлгээнд шалгуурыг дараах зорилгоор хэрэглэдэг:

- Олон нийтийг мэдээллээр хангах, эгэх хариуцлагыг сайжруулах;
- Үр дүн, сургамж бий болгох, тэдгээрийг дараагийн судалгаанд ашиглах замаар мэдлэг олгох үйл ажиллагааг дэмжих.

13. Шалгуурыг үнэлгээнээс гадна мониторинг, үр дүнгийн удирдлага, стратеги төлөвлөгөө, арга хэмжээний загвар боловсруулахад ашиглаж болно.

14. Шалгуурыг үйл явц (өөрчлөлт хэрхэн өрнөсөн) болон үр дүнг (юу өөрчлөгдсөн) тодорхойлоход мөн хэрэглэдэг. Бүх шалгуурыг арга хэмжээний өмнөх үе, хэрэгжиж байх үе эсвэл дараа үеийг нь үнэлэхэд ашиглаж болно.³

Шигтгээ 1. Арга хэмжээг үнэлэх

Бид “арга хэмжээ” гэсэн нэр томъёог үнэлгээний судлагдахуун гэдэг утгаар ашиглав. Арга хэмжээ нь төсөл хөтөлбөр, бодлого, стратеги, сэдэвчилсэн үйл ажиллагаа, техникийн туслалцаа, бодлогын зөвлөмж, институт, санхүүжилтийн механизм, арга хэрэгсэл, эсвэл бусад үйл ажиллагаа гэх мэт эдгээр шалгуурыг ашиглан үнэлж болох бүх төрлийн хөгжлийн болон хүмүүнлэгийн үйл ажиллагааг хамруулна. Мөн үүнд хөгжлийн төлөөх арга хэмжээ, хүмүүнлэгийн тусламж, энх тайвныг бэхжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, норматив ажил, төрөөс батлан даагаагүй санхүүжилт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг багтаан үздэг.

Шалгууруудыг олон улсын хамтын ажиллагааны арга хэмжээ, мөн дотоод бодлогын хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, үндэсний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлэхэд ашиглаж болно.

² Үнэ цэн, ач холбогдлын талаар ЭЗХАХБ-ын ХТХ-оос 1991 онд гаргасан ‘Хөгжлийн туслалцааны үнэлгээний зарчмууд’-аас харна уу.

³ Гэхдээ, энэхүү баримт бичигт шалгууруудыг тодорхойлохдоо дунд шатны, эцсийн болон дараах үнэлгээнд ашиглагддаг түгээмэл практикийг тусгасан болно.

2.2. Ашиглах зарчим

15. Шалгуурыг ашиглахдаа дараах зарчмыг баримтална. Нэмэлт зөвлөмж, жишээг дагалдах гарын авлагад (удахгүй гарах) тусгасан. ЭЗХАХБ ХТХ-ны *Хөгжлийн үнэлгээний чанарын стандартууд* нь үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх стандартыг тодорхойлно. Шалгуурын тодорхойлолтуудыг илүү өргөн хүрээнд ойлгож, үнэлгээг хэрхэн үр дүнтэй, чанартай явуулах тухай бусад зөвлөмж, гарын авлагатай уялдуулан авч үзэх нь чухал юм.

Нэгдүгээр зарчим

Үр дүнтэй, өндөр чанартай үнэлгээ хийхийн тулд шалгуурыг сайтар бодож хэрэглэх хэрэгтэй. Шалгуурыг тухайн үнэлгээний нөхцөл байдал, үнэлүүлж буй арга хэмжээний онцлог, оролцогч талуудад нийцүүлэн хэрэглэх нь чухал. Тухайн шалгуурыг хэрхэн ойлгож, шинжилгээ хийхэд үнэлгээний асуултууд (юу олж мэдэх гэж эрмэлзэж байгаа) болон асуултуудын хариултыг юунд ашиглахаар төлөвлөж буй мэдээлэл нь чухал нөлөөтэй.

Хоёрдугаар зарчим

Үнэлгээний зорилгоос хамаарч шалгуурын хэрэглээг тодорхойлно. Шалгуурыг механикаар шууд авч ашиглах нь зохимжгүй. Харин тэдгээрийг холбогдох оролцогч талуудын хэрэгцээ, үнэлгээний нөхцөл байдалд тохируулан хэрэглэх нь зүйтэй. Үнэлгээний зорилгоос хамааран шалгуур тус бүрийн хүрээнд дүн шинжилгээ хийхэд харилцан адилгүй цаг хугацаа, нөөц зарцуулах шаардлага тулгарч болно. Өгөгдлийн бэлэн байдал, нөөцийн хязгаарлалт, цаг хугацаа болон арга зүй нь тухайн шалгуурыг хэрхэн ашиглахад (эсвэл ашиглах эсэхэд) нөлөөлдөг.⁴

2.3. Тодорхойлолтууд ба тэдгээрт оруулсан өөрчлөлтийн тайлбар

16. Шалгуур тус бүрийн тодорхойлолтыг дараах хэсэгт авч үзэв. Тодорхойлолтыг илүү ойлгомжтой байлгахын тулд тэмдэглэл хэсгийг нэмж оруулав. Шигтгээ хэсэгт *Үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын үндсэн нэр томъёоны тайлбар толь* (ЭЗХАХБ, 2002) дахь тухайн тодорхойлолтын анхны хувилбарт оруулсан өөрчлөлтийг тайлбарлав. *Тайлбар толь*-ийн хоёр дахь хэвлэл бэлэн болж байгаа бөгөөд арга хэмжээ, үр дүн, гарц, үр дагавар болон зорилт гэх мэт энэхүү баримт бичигт ашигласан олон нэр томъёог тайлбарлан оруулсан тул уншигчдад хэрэгтэй эх сурвалж болох юм.

⁴ Үнэлэгдэх чадамжийн (үнэлгээ эхлэхээс өмнө хийгддэг) үнэлгээ нь ямар мэдээлэл үнэлгээ өгч чадах, ямар нотлох баримт цуглуулж болох, үнэлгээ нь асуултуудад хэрхэн хариулах талаар бодитой хүлээлт бий болгоход хэрэгтэй байдаг.

НИЙЦТЭЙ БАЙДАЛ: АРГА ХЭМЖЭЭ НЬ ЗӨВ ЗҮЙЛИЙГ ХИЙЖ БАЙНА УУ?

Тухайн арга хэмжээний зорилт, загвар нь үр өгөөж хүртэгчдийн⁵ глобал болон үндэсний, мөн хамтрагч/ байгууллагын хэрэгцээ, бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй байдал болон нөхцөл байдал өөрчлөгдсөн ч нийцтэй хэвээр хадгалагдах байдлыг илэрхийлнэ.

Тэмдэглэл: "Нийцэх" гэдэг нь тухайн арга хэмжээ хэрэгжиж буй эдийн засаг, хүрээлэн буй орчин, тэгш боломж, нийгэм, улс төр, эдийн засаг, чадавхын нөхцөл байдалд арга хэмжээний зорилт, загвар хэрхэн мэдрэг бөгөөд нийцтэй байхыг хэлнэ. "Хамтрагч/байгууллага" гэдэгт арга хэмжээг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавихад оролцож буй засгийн газар, нутгийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн, олон улсын байгууллагууд орно. Нийцтэй байдлын үнэлгээнд өөр өөр тэргүүлэх чиглэл эсвэл хэрэгцээний ялгаатай байдал, харилцан бүүлтыг авч үздэг. Мөн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, арга хэмжээ нийцтэй байдлаа хадгалахын (эсвэл хадгалсаар байхын) тулд зохих өөрчлөлт оруулахыг шаарддаг.

Шигтгээ 2. Нийцтэй байдлын тодорхойлолтод оруулсан өөрчлөлтийн тайлбар

Бид арга хэмжээний нийцтэй байдалтай холбоотой чанарын бусад хүчин зүйлийг тусгахын тулд “загвар”-г нэмсэн. Өөрөөр хэлбэл арга хэмжээний загварыг тэргүүлэх чиглэл буюу нэн тэргүүний асуудал/ хэрэгцээг шийдвэрлэх түвшинд сайн боловсруулсан байна уу (зорилтууд, өөрчлөлтийн онол, үйл ажиллагааны онол, арга барил, эрсдэлийн шинжилгээ, нөхцөл байдлын шинжилгээ гэх мэт) гэдгийг тусгах зорилгоор тодорхойлолтод оруулсан. Ингэснээр нийцтэй байдлын шинжилгээг илүү нарийвчлан хийх боломж бүрдэнэ. Харин арга хэмжээ нь зорилгодоо хүрсэн эсэхийг үр дүнтэй байдлаар, хэр зэрэг хэрэгжсэнийг үр ашигтай байдлаар үнэлнэ.

Нөхцөл байдлын шинжилгээг илүү гүнзгийрүүлэх үүднээс тухайн арга хэмжээ мэдрэг байвал зохих чухал хүчин зүйлүүдийг тэмдэглэлд тайлбарласан.

Бид үр өгөөж хүртэгчдийн “тэргүүлэх чиглэл буюу нэн тэргүүний асуудал”-ыг нэмж оруулсан нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хувьд (зөвхөн донор байгууллагууд, засгийн газарт бус) юу хамгийн чухал/яаралтай болохыг тодорхойлохын ач холбогдлыг тодотгох зорилготой. Түүнчлэн үр өгөөж хүртэгчдийг онцлон авч үзэх нь хөгжлөөс хэн ч үлдэж, орхигдох ёсгүй гэсэн одоогийн бодлогын тэргүүлэх чиглэлд нийцүүлсэн хэрэг юм. Мөн “шаардлага” гэдгээс илүү хялбар ойлгогдох “хэрэгцээ” гэдэг нэр томъёог ашигласан (шаардлага нь заримдаа хуулийн шаардлагатай андуурагддаг).

Зөвлөлдөөний үеэр “үр өгөөж хүртэгч” гэсэн нэр томъёотой холбоотой эргэлзээтэй саналууд гарсан. Учир нь үүнийг зөвхөн идэвх оролцоогүй хүлээн авагч гэж андуурах, эсвэл хүмүүст ашиг тустай байгаагүй ч тийм байсан мэт ойлгогдох эрсдэлтэй гэж үзсэн. Тухай арга хэмжээ нь хамааралтай, зорилтот хүмүүстээ хүрэх нийцлийг үнэлэхэд дэмжсэн тодорхой утга санаа агуулж буй учир энэ нэр томъёог үлдээв. Үл ойлголцлоос сэргийлэн нэр томъёог хөлийн тэмдэглэлд тодорхойлж, хувилбарт нэршлийг мөн санал болголоо.

Бид 2030 Хөтөлбөр болон Парисын хэлэлцээрт тусгагдсан “дэлхийн тэргүүлэх чиглэл”-ийг хэвээр үлдээв. Бодлогын чиглэлүүд өөрчлөгдөж, нийцтэй байдлын шалгуур нь өөр өөр үнэлгээнд хэрэглэгдэх тул эдгээрийг тодорхойлолтод нэг бүрчлэн дурдаагүй.

⁵ Үр өгөөж хүртэгчид гэдэгт “Зорилтот бүлэг байсан эсэхээс үл хамааран тухайн арга хэмжээнээс шууд эсвэл шууд бусаар үр өгөөж хүртсэн хувь хүн, бүлэг, байгууллага”-ыг ойлгох ба “нөхцөл байдлаас хамааран эрх эдлэгч тал, үүрэг хүлээгч тал, эсвэл нөлөөлөлд өртсөн хүн гэх мэт өөр нэр томъёо хэрэглэдэг”.

Нийцтэй байдлыг арга хэмжээний загвар боловсруулах үед болон дараа нь үнэлж болох тул тодорхойлолтод цаг хугацааны хүрээг (өмнө нь тайлбар хэсэгт орсон байсан) тодорхой дурдсан. Ийнхүү дурдах нь чухал хэрэгтэй бөгөөд нарийн төвөгтэй эсвэл өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицож, хариу үйлдэл үзүүлэх нь арга хэмжээний үр дүнтэй байдлыг тодорхойлоход чухал. Нийцтэй байдлыг тодорхойлсон өмнөх хувилбарын хүрээнд уг шалгуурыг ихэвчлэн бодлогын тэргүүлэх чиглэлд нийцсэн эсэхийг үнэлэх нэг төрлийн үнэлгээ болгон ашигладаг байв.

Хөгжлийн хамтын ажиллагаанаас илүү өргөн цар хүрээнд шалгуурын хэрэглээг тусгахын тулд “хандивлагч буюу донор” гэсэн нэр томъёог хасаж, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавихад оролцдог байгууллагуудыг (орон нутгийн, олон талт, хувийн хэвшлийн гэх мэт) хамруулсан хамтрагч/байгууллага гэсэн нэр томъёог тайлбарласан тэмдэглэл нэмж оруулав.

Оролцоо ба өмчлөл гэсэн утга санааг тодорхойлолтоос хассан. Учир нь эдгээр нь энэ шалгуурыг тодорхойлох хэмжигдэхүүн бус нийцтэй байдалд (мөн үр дүнтэй байдал, тогтвортой байдалд) нөлөөлөх хүчин зүйл болох юм. Эдгээр ойлголтыг гарын авлагад авч үзнэ.

Тайлбар толь дахь нийцтэй байдлын тодорхойлолт: “Тухайн арга хэмжээний зорилтууд, дизайн нь үр өгөөж хүртэгчдийн шаардлага, үндэсний хэрэгцээ, дэлхийн тэргүүлэх чиглэл, хамтрагч болон хандивлагч байгууллагын бодлогын зорилтод нийцэж буй байдал. Тэмдэглэл: Нийцтэй байдлын асуудал нь ихэвчлэн эргээд харахад арга хэмжээний зорилт болон загвар нь өөрчлөгдсөн нөхцөл байдалд ч тохиромжтой хэвээр байгаа эсэх тухай асуулт болдог.”

УЯЛДАА ХОЛБОО: АРГА ХЭМЖЭЭ ХЭР УЯЛДАА ХОЛБООТОЙ БАЙНА ВЭ?

Тухайн арга хэмжээ нь үндэсний, салбарын эсвэл байгууллагын түвшинд явагдаж буй бусад арга хэмжээтэй уялдсан байдал.

Тэмдэглэл: Өөр бусад арга хэмжээ (ялангуяа бодлогын түвшний) тухайн арга хэмжээг дэмжиж эсхүл сөргөөр нөлөөлж буй байдал, эсвэл эсрэгээрээ тухайн арга хэмжээ нь бусад арга хэмжээнд нөлөөлж буй байдлыг илэрхийлнэ. Үүнд дотоод ба гадаад уялдаа холбоог авч үзнэ: **Дотоод уялдаа холбоо** нь нэг байгууллага, эсхүл засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь холбоо хамаарал бүхий цогц, өөр хоорондоо харилцан уялдаатай байхын зэрэгцээ тухайн байгууллага, засгийн газрын мөрдлөг болгодог олон улсын холбогдох хэм хэмжээ, стандарттай нийцсэн байдлыг тодорхойлно. **Гадаад уялдаа холбоо** нь бусад байгууллагуудаас ижил нөхцөлд хэрэгжүүлж буй арга хэмжээтэй тухайн арга хэмжээний уялдсан байдлыг тодорхойлно. Үүнд харилцан бие биеэ нөхөх, зохицолдоог хангах, зохицуулах, хүчин чармайлтын давхардлаас зайлсхийхийн зэрэгцээ тухайн арга хэмжээнд оруулж буй үнэ цэн зэргийг авч үзнэ.

Шигтгээ 3. Уялдаа холбоо гэх шалгуур нэмсэн талаар болон тодорхойлолтын тайлбар

Энэ шалгуур нь өмнө тодорхойлж байгаагүй чухал үтгэ санааг агуулсан. Уялдаа холбоо дутмаг байх нь аливаа хүчин чармайлтыг давхардуулан хийхэд хүргэж, ахиц дэвшил гарахад сөргөөр нөлөөлөх боломжтой. Энэ шалгуурыг нэмснээр дээрх чухал асуудалд дүн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлнэ. Уялдаа холбоог үнэлэх шалгуур нь зөвхөн аливаа нэг арга хэмжээ эсвэл байгууллагын түвшинд төвлөрч, үнэлгээ хийхийн оронд тухайн арга хэмжээ нь системийн түвшинд (байгууллага, салбар, сэдэвчилсэн үйл ажиллагаа, улс орон) ямар үүрэгтэй болохыг ойлгоход дэмжлэг үзүүлнэ.

Өнөөгийн нөхцөлд уялдаа холбоотой байдлыг чухалчлан авч үзэх хэрэгтэй. Учир нь бодлогын чиглэлүүдийн холбоо хамаарал (эсвэл харилцан буулт)-ыг онцгойлон үзэх нь нэмэгдсэн бөгөөд мөргөлдөөн, хүмүүнлэгийн тусламж болон уур амьсгалын асуудлыг шийдвэрлэхэд засгийн газар хоорондын хамтын ажиллагаанд анхаарал хандуулах нь ихэссэн. Мөн тогтвортой хөгжилд чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэрүүд (олон улсын болоод дотоодын) улам бүр төрөлжиж байна.

“Олон улсын хэм хэмжээ, стандарт”-ыг дурдсанаар арга хэмжээ нь авлигын эсрэг заалтууд, хүний эрхийн конвенц зэрэг олон улсын хууль, гэрээний хүрээнд дагаж мөрдөхөөр хэрэгжүүлэгч этгээдийн хүлээсэн үүрэгтэй уялдах байдлыг шинжлэн судлах боломжийг олгоно. Үүнд тухайн хэрэгжүүлэгч этгээдийн гэрээгээр хүлээсэн бүхий л үүрэг хамаарах ба эдгээрийг дотоод уялдаа холбооны хүрээнд авч үзнэ. Өмнө нь энэ төрлийн уялдаа холбооны талаар хангалттай хэмжээнд дүн шинжилгээ хийдэггүй байсан. Дэлхийн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулна гэдэг өнцгөөс харвал олон улсын хэм хэмжээ, стандартуудыг нийцтэй байдлыг үнэлэх шалгуурын хүрээнд мөн авч үзэж болох бөгөөд энэ нь асуудлыг өөр өнцгөөс харах боломжийг олгох юм.

ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ: АРГА ХЭМЖЭЭ ЗОРИЛГУУДДАА ХҮРЧ БАЙНА УУ?

Тухайн арга хэмжээ төлөвлөсөн зорилго, хүлээгдэж буй үр дүндээ хүрсэн байдал, үүний дотор төрөл бүрийн бүлгүүдийн хувьд гарсан ялгаатай үр дүн.

Тэмдэглэл: Үр дүнтэй байдлын шинжилгээ нь зорилго эсвэл үр дүнгийн харьцангуй ач холбогдлыг харгалзан үздэг.

Шигтгээ 4. Үр дүнтэй байдлын тодорхойлолтод оруулсан өөрчлөлтийн тайлбар

Үр дүнтэй байдал нь үр дүнгийн гинжин хэлхээ / шалтгаан үр нөлөөний холбоосоор дамжуулан зорилтдоо хүрэх үйл явцад дүн шинжилгээ хийдэг болохыг бид тодотгосон. Нөлөөлөл буюу аливаа арга хэмжээний өндөр түвшинд үзүүлж буй нөлөө, өргөн хүрээний өөрчлөлттэй харьцуулахад үр дүнтэй байдал нь шууд хамаатуулж болох үр дүнгийн талаар авч үздэгээрээ ялгаатай.

“Үр дүн” болон “ялгаатай үр дүн” гэх ойлголтыг нэмсэн нь өөр өөр бүлгүүдийн хувьд үр дүн хэрхэн ялгаатай байж болохыг судалж, улмаар арга хэмжээний анхны зорьсон зорилгоос давуулан харах боломжийг олгоно. Энэ нь хөгжлөөс хэн ч үлдэж, орхигдох ёсгүй гэсэн бодлогын тэргүүлэх чиглэлтэй нийцнэ. Мөн тэгш боломжийн асуудал нь арга хэмжээний үндсэн зорилгод хамаагүй байсан нь тэгш боломж, гадуурхагдсан бүлгүүдийн хувьд ямар үр дүн гарсныг шинжлэн судлах боломжийг бүрдүүлнэ.

Тодорхойлолтын агуулга нь үнэлгээчдийг сонирхсон зорилго болон/эсвэл үр дүнд анхаарлаа илүү төвлөрүүлэн судлах уян хатан боломжоор хангана.

Үр дүнтэй байдлын талаар ерөнхий дүгнэлт хийхдээ хүрсэн/хүрээгүй/хүлээгдэж буй зорилго, үр дүнгийн ач холбогдлыг харгалзан үзэх шаардлагатай тул тэмдэглэлд "харьцангуй ач холбогдол"-ын тайлбарыг хэвээр үлдээв. Нөгөөтээгүүр, нийцтэй байдлын хүрээнд ерөнхий дүгнэлт хийхдээ аливаа арга хэмжээ гол оролцогч талуудын хувьд хэр зэрэг тэргүүлэх ач холбогдолтой болохыг үнэлнэ. Арга хэмжээ ямар нөлөө үзүүлж, хэр зэрэг ач холбогдолтой болсныг нөлөөлөл гэх ойлголтоор авч үзнэ.

Тайлбар толь дахь үр дүнтэй байдал нэр томъёоны тодорхойлолт: “Хөгжлийн арга хэмжээний зорилтуудын харьцангуй ач холбогдлыг харгалзан үзсэний үндсэн дээр зорилтуудад хэр зэрэг хүрсэн эсвэл хүрэх хүлээлттэй байгааг илэрхийлнэ. Тэмдэглэл: Мөн үйл ажиллагааны ач холбогдол, үнэ цэний нэгдсэн хэмжүүр (эсвэл түүний талаарх дүгнэлт) болгон ашигладаг, өөрөөр хэлбэл арга хэмжээ нь хэр үр ашигтайгаар, тогтвортой байдлыг хангаж, институцын хөгжилд эерэг нөлөө бүхий үр нөлөөтэй байдлаар холбогдох гол зорилгодоо хүрсэн эсвэл хүрэх хүлээлттэй байгааг тодорхойлно.”

ҮР АШИГТАЙ БАЙДАЛ: НӨӨЦИЙГ ХЭР САЙН АШИГЛАСАН БЭ?

Тухайн арга хэмжээ үр дүнг хэмнэлттэй, цаг хугацаанд нь бий болгосон байдал

Тэмдэглэл: “Хэмнэлттэй” гэдэг нь орцыг (хөрөнгө, мэргэжлийн туршлага, байгалийн нөөц, цаг хугацаа зэрэг) тухайн нөхцөл байдалд боломжит хувилбаруудтай харьцуулахад хамгийн бага зардлаар гарц, эцсийн үр дүн, нөлөөлөл болгон хувиргахыг хэлнэ. “Цаг хугацаанд нь” гэдэг нь төлөвлөсөн хугацаанд эсвэл үүссэн нөхцөл байдлыг харгалзан тогтоосон цаг хугацаанд хийж гүйцэтгэхийг хэлнэ. Үүнд мөн ажиллагааны үр ашиг (арга хэмжээг хэр сайн удирдсан)-ийг оруулан үнэлж болно.

Шигтгээ 5. Үр ашигтай байдлын тодорхойлолтод оруулсан өөрчлөлтийн тайлбар

Үр ашигт байдал нь үнэлгээний сайн туршлагын дагуу үр дүнгийн бүх гинжин хэлхээнд (гарц, үр дүн, үр нөлөө) хамаарах орцыг авч үзэж болохыг бид тодотгосон. Үр дүнгийн гинжин хэлхээнд бүхлээр нь дүн шинжилгээ хийх, ялангуяа орцоос нөлөөлөлд хүртэлх үр ашгийг судлах нь арга зүйн хувьд нарийн төвөгтэй. Жишиг өгөгдөл ихэвчлэн байдаггүй. Гэсэн хэдий ч энэ нь анхаарал татсан сэдэв тул бид нөлөөлөлтэй холбоотой хэсгийг хэвээр үлдээсэн. Энэ нь хэрэглэгчдэд үр дүнгийн гинжин хэлхээний үнэлгээнд хамгийн их хамааралтай хэсэгт төвлөрүүлэн үр ашгийн дүн шинжилгээг уян хатан хийх боломжийг олгоно.

"Нөхцөл байдлын хувьд боломжит хувилбаруудтай харьцуулахад" гэж нэмснээр үр өгөөжийн бодит дүн шинжилгээ хийх нь арга хэмжээний үнэ цэнийг холбогдох эсрэгцүүлэх баримтуудтай харьцуулахыг шаарддаг гэсэн санааг бататгаж байна: хамгийн зардал багатай арга хэмжээ нь хангалттай үр өгөөжийг бий болгохгүй бол хамгийн сайн сонголт байх албагүй.

Арга хэмжээний үнэ цэний чухал хэсэг болох цаг хугацааны хэмжигдэхүүнийг зарим тохиолдолд орхигдуулсан байдаг тул бид үүнийг нэмж оруулсан.

Хэрэгжилтийн үйл явц, менежментийн асуудлууд нь үнэлгээнд оролцогч талуудын сонирхлыг ихээхэн татдаг тул бид ажиллагааны үр ашиг хэмээн тусгайлан дурдсан. Энэ нь тухайлбал, зохицуулалтын механизм гүйлгээний зардлыг нэмэгдүүлсэн ч уялдаа холбоог сайжруулсан эсэхийг судлахад хэрэгтэй.

Тайлбар толь дахь үр ашигтай байдлын тодорхойлолт: “Нөөц/орц (санхүүжилт, туршлага, цаг хугацаа гэх мэт) нь хэр хэмнэлттэйгээр үр дүнд хувирч байгааг хэмжих хэмжүүр.”

НӨЛӨӨЛӨЛ: АРГА ХЭМЖЭЭ НЬ ЯМАР ӨӨРЧЛӨЛТИЙГ БИЙ БОЛГОХ ВЭ?

Тухайн арга хэмжээний улмаас үүссэн төлөвлөсөн эсвэл төлөвлөөгүй, өндөр түвшний эерэг болон сөрөг нөлөө бий болсон эсвэл болж болзошгүй байдал.

Тэмдэглэл: Нөлөөлөл гэдгээр тухайн арга хэмжээний туйлын ач холбогдол, суурь шинжтэй өөрчлөлт бий болгох нөлөөг авч үздэг. Үүгээр арга хэмжээний үр дүнтэй байдлын шалгуурт авч үзсэнээс илүү урт хугацааны, өргөн хүрээний нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засгийн нөлөөг тодорхойлохыг зорьдог. Нөлөөлөлд тухайн арга хэмжээний шууд үр дүнгээс цааш шууд бус, хоёрдогч, боломжит үр дагавруудыг мөн авч үздэг. Чингэхдээ тогтолцоо эсвэл хэм хэмжээнд гарсан цогц, тогтвортой өөрчлөлт болон иргэдийн аж байдал, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, хүрээлэн буй орчинд үзүүлж болох нөлөөг авч үзнэ.

Шигтгээ 6. Нөлөөллийн тодорхойлолтод оруулсан өөрчлөлтийн тайлбар

Бид нөлөөллийн ач холбогдол, хамрах хүрээ, хувьсан өөрчлөгдөх шинж чанарыг илрүүлэхийн тулд “өндөр түвшин” гэх ойлголтыг нэвтрүүлсэн. Тэмдэглэл хэсэгт үүний утга, агуулгыг тайлбарлав. Энэ утга нь өөрчлөлт шинэчлэлтийг уриалсан 2030 Хөтөлбөр болон Парисын Хэлэлцээрийн хүрээнд бодлогын хамааралтай.

Энэхүү тодорхойлолт нь нөлөөлөл гэдэг үгийн аливаа юмс үзэгдлийн утга учир бүхий эсвэл чухал өөрчлөлтийг илэрхийлсэн нийтлэг хэрэглээтэй илүү нийцэж байна.

Нөлөөлөл гэдэг нэр томъёо нь зарим хэрэглэгчдийн ашигладаг бодит атрибут (“нөлөөллийн үнэлгээ”-нд түгээмэл ашиглагддаг) гэх ухагдахуунтай андуурагддаг. Гэхдээ бид бодит атрибут нь бүх шалгуурт тусгагдсан гэж үздэг.

Шууд болон анхдагч нөлөө нь үр дүнтэй байдлын хүрээнд тодорхойлогдох учир “шууд болон шууд бус” мөн “анхдагч болон хоёрдогч” гэх утгыг бид хассан. Үр дүнтэй байдал болон нөлөөлөл хоорондыг ялгааг ойлгоход тэмдэглэл хэсэг тус болно.

Тайлбар толь дахь нөлөөллийн тодорхойлолт: “Шууд эсвэл шууд бус, төлөвлөсөн эсвэл төлөвлөөгүй байдлаар хөгжлийн арга хэмжээнээс үүссэн эерэг болон сөрөг, анхдагч болон хоёрдогч урт хугацааны нөлөөг хэлнэ.”

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ: ҮР ӨГӨӨЖ ЦААШИД ҮРГЭЛЖЛЭХ ҮҮ?

Арга хэмжээний цэвэр үр өгөөж тогтвортой хадгалагдан үргэлжлэх эсвэл үргэлжлэх боломжтой байдал.

Тэмдэглэл: Цаашид цэвэр үр өгөөжийг тогтвортой хадгалахад шаардлагатай санхүү, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин, институцын чадавхад хийсэн дүн шинжилгээг илэрхийлнэ. Үүнд мөн тэсвэрлэх чадвар, эрсдэл, боломжит харилцан буултын дүн шинжилгээ багтана. Үнэлгээ хийж буй цаг хугацаанаас хамааран арга хэмжээний цэвэр өгөөжийн бодит урсгалын дүн шинжилгээ эсвэл дунд болон урт хугацаанд хадгалагдах цэвэр үр өгөөжийн магадлалыг тооцно.

Шигтгээ 7. Тогтвортой байдлын тодорхойлолтод оруулсан өөрчлөлтийн тайлбар

Тодорхойлолт нь товч бөгөөд тайлбар тэмдэглэлд дүрдсанчлан тогтвортой байдал нь олон төрлийн хэмжигдэхүүнтэй (санхүү, эдийн засаг, нийгэм, байгаль орчин) болохыг тодотгов.

Анхны тодорхойлолт нь хандивлагч байгууллага төвтэй байсан бөгөөд зөвхөн гаднын санхүүжилт (хөгжлийн томоохон тусламж) дээр төвлөрч байсан нь өнөөгийн хөгжлийн үнэлгээний нөхцөлийг хангалттай тусгаж чадаагүй байв. Түүнчлэн санхүүжилт эсвэл үйл ажиллагаа үргэлжилж байх үед тогтвортой байдлыг үнэлэх нь ач холбогдолтой байдаг. Гаднын санхүүжилттэй холбоотой тодорхойлолтыг хэрэглэхгүй байснаар олон төрлийн нөхцөл байдалд тогтвортой байдлын үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэв.

Мөн тэмдэглэл хэсэгт тайлбарласнаар боломжит харилцан буулт болон үр өгөөжийг үргэлжлүүлэх суурь нөхцөлийн хүчин чадал/тогтолцооны тэсвэртэй байдалд дүн шинжилгээ хийж болно. Өмнөх тодорхойлолт нь давтагдсан хэллэг агуулж байсныг тодотгов ("урт хугацаанд үр өгөөж үргэлжлэх" болон "эрсдэлд тэсвэртэй байдал").

Бид арга хэмжээтэй холбогдон гарч буй зардлыг харгалзан үзэж, арга хэмжээний нийт үнэ цэнийг үргэлжлүүлэхэд голлон анхаарсан "цэвэр" үр өгөөж гэх нэр томъёог ашиглав.

Тайлбар толь дахь тогтвортой байдлын тодорхойлолт: "Хөгжлийн томоохон тусламж хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа хөгжлийн арга хэмжээний үр өгөөж үргэлжлэх байдал. Урт хугацаанд үр өгөөжийн үргэлжлэх магадлал. Цэвэр үр өгөөжийн эрсдэлд тэсвэртэй байдал нь цаг хугацаа өнгөрөхөд хэвээр байх."



Хураангуй

Энэхүү баримт бичигт ЭЗХАХБ-ын ХТХ-ны харьяа Хөгжлийн үнэлгээний сүлжээ (EvalNet) нь 2018-2019 онд ХАЭЗХБ ХТХ-ны үнэлгээний шалгуурын тодорхойлолт ба хэрэглээг хэрхэн дахин авч хэлэлцсэнийг тайлбарлав. Баримт бичигт хамааралтай байдал, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал, нөлөөлөл, тогтвортой байдал болон нэгэн шинэ шалгуур болох үялдаа холбоотой байдлын шинэчилсэн тодорхойлолтуудыг тусгасан. Баримт бичиг нь аливаа арга хэмжээний нөхцөл байдал, зорилтот хэрэглэгчдийн хэрэгцээг хэрхэн сайтар харгалзан үзсэний үндсэн дээр шалгууруудыг хэрэглэх талаар тайлбарласан.

Шинэчлэн боловсруулсан эдгээр тодорхойлолт, ашиглах зарчим нь шалгуурын талаарх дэлхийн хэмжээний зөвлөлдөөний хүрээнд тэдгээрийг үнэлгээнд болон бусад зорилгоор хэрхэн ашиглаж байгааг нарийвчлан судалж, хэлэлцсэний үр дүн юм. Зөвлөлдөөний мөрөөр EvalNet-ийн гишүүд болон гишүүн бус үнэлгээний мэргэжилтнүүд ойлголт, тодорхойлолтыг гүнзгийрүүлэн хэлэлцэж, баримт бичгийн төслийн хэд хэдэн хувилбарыг хянан эцэслэсэн. Шинэчлэн боловсруулсан тодорхойлолтууд нь илүү ойлгомжтой бөгөөд өнөөгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй үялдаж, тэгш боломж, хамтын ажиллагааг багтаасан илүү нягт нарийн бөгөөд чамбай дүн шинжилгээ хийхэд дэмжлэг болно. Ойлголт, тодорхойлолтын талаарх төөрөгдлийг багасгах үүднээс шинэчилсэн хувилбарт тухайн шалгуурын зорилгын тухай танилцуулга, хэрэглээг чиглүүлэх зарчмыг нэмж тусгасан. Мөн шалгуурыг танилцуулсны дараа тэдгээрийг хэрхэн ашиглах талаар нарийвчилсан зааврыг боловсруулан гаргана.

ХТХ-ны Хөгжлийн үнэлгээний сүлжээ нь энэхүү баримт бичгийг 2019 оны 11-р сарын 20-нд БАТЛАВ; улмаар 2019 оны 12-р сарын 10-ны өдрийн ХТХ-ны хурлаар нийтэд ил тод болгож, хэрэглээнд НЭВТРҮҮЛЭВ.

© OECD 2019

www.oecd.org/dac/evaluation

